



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/142

Мөрөн сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө”-г нэгдүгээр хавсралтаар, “Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар баталсугай.


2.Нутаг дэвсгэр, байгууллага, орчиндоо “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажил, аяныг үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.


3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





Аймгийн Засаг даргын 2024 оны
4 дүгээр сарын 02-ны өдрийн
А/142 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ХӨВСГӨЛ АЙМАГТ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардлагат ай төсөв /сая төгрөг/	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Гарах үр дүн
Нэг: Аян арга хэмжээ, сургалт, сурталчилгаа					
1	Эрх зүйн сургалт, сурталчилгааг орон нутагт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэх	7-9 сард	500,000	Хууль, эрх зүйн хэлтэс Өмгөөлөгчдийн зөвлөл, Прокурорын газар, Цагдаагийн газар,	Иргэдийн эрх зүйн мэдлэг сайжирч, мэдээллийн эх сурвалж нэмэгдэнэ.
2	Хорих ангиас суллагдсан иргэнд нийгэмд дасан зохицоход шаардлагатай мэдээллүүдийг өгөх, Хөдөлмөрт бэлтгэх суурь сургалт, Мэргэшүүлэх түр сургалтад хамруулах, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх	3,4-р улирал	-	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөвсгөл аймаг дахь Политехникийн коллеж,	Хорих ангиас суллагдсан иргэд дахин гэмт хэрэгт холбогдох нь багасаж байнгын тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх боломжууд бий болно.
3	“Сайн жолооч” аяныг зохион байгуулах	2, 3 дугаар улиралд	500,000	Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн газар,	Зам тээврийн осол саатал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах

4	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зорилтот нэвтрүүлэг хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах	Жилдээ	500,000	Хууль, эрх зүйн хэлтэс Өмгөөлөгчдийн зөвлөл, Прокурорын газар, Цагдаагийн газар,	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцоо нэмэгдэнэ.
Хоёр: Хяналт шалгалт, зөвлөн туслах чиглэлээр					
1	Аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилд үйлдэгдэж байгаа гэмт хэрэгт мэргэжлийн байгууллагаар криминологи судалгааны ажил хийлгэх.	Жилдээ	-	Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар	Гэмт хэргийн өсөлт, шалтгаан нөхцөл, цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхойлох.
2	“Хүүхэд хяналт” арга хэмжээг зохион байгуулах. (РС тоглоомын газар, баар, ресторан, буудал, биллиард, насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалын дагуу холбогдох газруудад)	Улирал бүр	100,000	Аймгийн ГХУСАЗСЗ, ГБХЗХГ, ЦГ,	Салбарын байгууллагуудын оролцоотой хүүхэд, өсвөр үеийнхнийг аливаа эрсдэл, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
3	Аялал жуулчлалын улиралд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлдэг газруудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, хяналт шалгалт зохион байгуулах	2-3-р улиралд	1,000,000	Цагдаагийн газар	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжинэ, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх
4	Мал мах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд чиглэсэн хяналт шалгалтын 24 цагийн пост ажиллуулах	4-р улиралд	2,000,000	Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ,	Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох илрүүлэх
Гурав: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр					

1	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зан үйлд нөлөөлөх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	Улирал бүр	500,000	Аймгийн ГХУСАЗСЗ, ГБХЗХГ, Цагдаагийн газар,	Гэр бүлийн хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих, олон нийт, иргэдийн хандлага төлөвшиж, эрх зүйн боловсрол дээшилнэ.
2	Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, агуулга, ирээдүйд үүсэх үр дагавар, хор уршиг, хүлээх хариуцлагын талаар сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах.	Жилдээ	-	Аймгийн ГХУСАЗСЗ,	Гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.
3	Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр “Мэддэг нь мэдээллэдэг байя” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулах	2-3-р улиралд	200,000	Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар,	Гэр бүлийн хүчирхийллийн илрүүлэлтийн хувь нэмэгдэнэ.
Дөрөв: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр					
1	Төрийн байгууллагаас үйлчилгээ авахад иргэдэд учрах хүндрэл, бэрхшээл, үйлчилгээний тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бууруулах, төрийн байгууллагын хүнд суртал, олон үе шат дамжлагыг багасгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян зарлах (Тусгайлан удирдамж, хөтөлбөрийн дагуу)	Жилдээ	5,000,000	Хууль, эрх зүйн хэлтэс	Төрийн байгууллагын үйлчилгээний чанар сайжирч, авлига, албан тушаалын гэмт хэргийн гаралт буурна.
2	Төрийн албан хаагч, иргэдэд Авлигатай тэмцэх тухай хууль тогтоомж, түүнээс гарах үр дагаврыг таниулах эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах	Жилдээ	1,000,000	Хууль эрх зүйн хэлтэс	Төрийн албан хаагч авлига авах магадлал буурна.

Тав: Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр					
1	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд ажиллах "Сэтгэл зүйчдийн баг"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах (Багийн тусгайлан төлөвлөгөөний дагуу)	Жилдээ	500,000	Хууль, эрх зүйн хэлтэс, ГБХЗХГ	-Тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт буурах, урьдчилан сэргийлэх, Сэтгэл зүйчийн багийн үйл ажиллагаа тогтмолжино. -Иргэдэд сэтгэл зүйч мэргэжил, сэтгэл боловсролын талаар бодитой ойлголтод хүрсэн байна.
2	Аймгийн хэмжээнд 2021-2022 онд "Амиа хорлох" гэмт хэрэг, түүн дотор хүүхэд амиа хорлох гэмт хэргийн гаралт их байгаагаар холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан амиа хорлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхдийн сэтгэхүйд тохирсон "Жүжгийн зохиолын уралдаан" зарлах, шалгарсан жүжгийг найруулан тавиулах, соёл, урлагийн байгууллага болон сургуулийн захиргаагаар хамтран ажиллах.	Жилдээ	2,000,000	Хууль, эрх зүйн хэлтэс	Амиа хорлох гэмт хэргийн гаралт буурсан байна.
3	"Запилах", "Хүн алах", "Хүчиндэх" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн аяныг зохион байгуулах	3-4-р улиралд	500,000	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	Урьдчилан сэргийлэх
4	Амиа хорлох гэмт хэргийн эсрэг ухуулга, сурталчилгаа зохион байгуулах	2 дугаар улиралд	500,000	Хууль эрх зүйн хэлтэс	Амиа хорлох гэмт хэргийн гаралт буурна.
Зургаа: Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр					
1	"Хамтдаа хамгаалъя" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	Жилдээ	500,000	Хууль, эрх зүйн хэлтэс,	Хүүхдэд тавих эцэг эхийн хараа хяналт сайжирна.

	Арга хэмжээний хүрээнд видео контент бэлтгэн иргэдэд хүргэх, нөлөөллийн самбар байршуулах.				Цагдаагийн газар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Хүүхэд, өсвөр үеийнхнийг аливаа эрсдэл, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголттой болно.
2	“Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-ээр хүүхэд өсвөр үеийнхэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таниулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Улирал бүр	200,000	Аймгийн ГХУСАЗСЗ, ГБХЗХГ, ЦГ,		Өсвөр үеийнхний дунд үйлдэгдэж буй үе тэнгийн дарамт, хүчирхийллийн тоо буурч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл сайжирна.
3	Үе тэнгийн дарамт, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үе тэнгийн сургагч багш бэлтгэж, чадавхжуулах	1-р улиралд	500,000	Аймгийн ГХУСАЗСЗ, ГБХЗХГ		Өсвөр үеийн хүүхдүүдийн үйлдэгдэх, өртөх гэмт хэрэг буурсан байна.
4	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах болон дунд ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аян өрнүүлж, сургалт зохион байгуулах.	2,4 улиралд	300,000	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар		Цахим орчны гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж, тодорхой мэдлэгтэй болно
5	Хүүхэд, өсвөр үеийнхнийг цахим орчны гэмт хэрэг, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох чиглэлээр хүүхэд хамгааллын байгууллагатай хамтран ажиллах.	3, 4-р улиралд	200,000	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар,		
Долоо: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр						
1	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар санал санаачилга гарган үр дүнд хүрсэн сум, баг хоршоо,	Жилдээ	300,000	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	Мал хулгайлах гэмт хэргийн талаарх мэдээлэл хүрсэн байна.	

	нөхөрлөл, айл өрх, иргэдийн тэргүүн туршлагыг нийтэд сурталчлах							
2	Өмчлөх эрхийн эсрэг үйлдэгддэг тодорхой төрлийн гэмт хэргийн талаар аян өрнүүлэх	Жилдээ	300,000	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт багассан байна.			
Найм: Сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр								
1	Тухайн нутаг дэвсгэртээ үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг сумын удирдлага, сумын ИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлтийг бууруулах. (Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тусгайлсан төлөвлөгөө гаргаж зохион байгуулах)	Жилдээ	500,000	Сумын ИТХ, сумын Засаг дарга	Тухайн нутаг дэвсгэрийнхээ гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, хамтын ажиллагааг сайжруулсан байна.			
2	Сумдын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа этгээдүүдийг дахин гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль эрх зүйн талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	300,000	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хууль эрх зүйн хэлтэс	Дахин гэмт хэрэг зөрчил үйлдэгдэхээс урьдчилсан сэргийлж, гэмт хэргийн хор уршгийн талаар мэдлэгтэй болсон байна.			
3	Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран малчин, ажилгүй иргэдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	200,000	Сумын ИТХ, сумын Засаг дарга, Хууль, Эрх зүйн хэлтэс,	Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаа иргэдийн тоо буурна, хууль эрх зүйн мэдлэг нь дээшилнэ.			

---oOo---

Аймгийн Засаг даргын 2024 оны
4 дүгээр сарын 02-ны өдрийн
А/1.42 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН
2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сургалтын нэр	Хэрэгж үүлэх хугаца а	Сургалтын хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Сургалтын ерөнхий зохион байгуулагч	Хамтран зохион байгуула гч
1	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх сургалт зохион байгуулах	Жилдэ э	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна	Архивын тасаг	ХЭЗХ
2	ERP төрийн байгууллагын цахим дотоод сүлжээг ашиглах мэргэшлийн ур чадвараа хөгжүүлэх нь сургалт зохион байгуулах	Жилдэ э	Цахим системийг ажлын байранд бүшрэн эзэмшсэн байна	ТЗУХ	ХЭЗХ
3	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7.4:10 сургалт	Тухай бүр	ТАХ-ын ёс зүйн харилцаа, удирдлага зохион байгуулалтын ажлын шинж мэдээлэл авсан байна.	ТЗУХ	ХЭЗХ
4	Шинэчлэн батлагдсан хуулийн талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Жилдэ э	Шинээр батлагдсан хууль тогтоомжийн мэдлэгтэй болсон байна	ХЭЗХ	ТЗУХ

5	Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт зориулсан сургалт зохион байгуулах	Жилдэ э	Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарыг чадавхижуулж мэдлэг олгосон байна	ХЭЗХ	Монголын нотариат ын танхимын Хөвсгөл аймаг дахь салбар
6	“Эрх зүйн хөтөч” нарт зориулсан сургалт зохион байгуулах	Жилдэ э	Эрх зүйн хөтөч нарт мэдлэг олгосон байна	ХЭЗХ	ХЗҮХ
7	“Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах” үйл ажиллагааны хүрээнд сургалт зохион байгуулах	Жилдэ э	Төрийн албан хаагч, иргэдэд хүний эрхийн талаар мэдлэг олгосон байна	Хүний эрхийн Үндэсний комиссийн Хөвсгөл аймаг дахь Референт	ХЭЗХ
8	Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн сургалт сурталчилгаа зохион байгуулах	Жилдэ э	Иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгосон байна	Онцгой байдлын газар	ХЭЗХ
9	Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт болон хүүхдээс үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх.	Жилдэ э	Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг болон хүүхдээс үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх.	ХЭЗХ	Авлигатай тэмцэх газар
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад зориулсан эрх зүйн сургалт зохион байгуулах	Жилдэ э	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад эрх зүйн мэдлэг олгосон байна	ХЭЗХ, ГБХЗХГ, ХХҮГ	
11	Эрх зүйн сургалт, сурталчилгааг 23 сум 1 тосгоны иргэд, төрийн албан хаагчдад үр дүнтэй зохион байгуулах, эрх зүйн хөтөч нарын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлэх.	Жилдэ э	Хууль тогтоомжийг иргэдэд таниулах, мэдээллийг шуурхай хүргэсэн байна.	ХЭЗХ	

12	Сумдад үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тухай сургалт зохион байгуулах	Жилдэ э	Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байна	ХЭЗХ	Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнүүд
13	Эрх зүйн суртчилгааны гарын авлага танилцуулга мэдээлэл (цахим хуудас, вэб сайт, сэтгүүл)-ийг иргэдэд хүргэх	Жилдэ э	Урьдчилсан төлөвлөлт хийж зохион байгуулсан байна	ХЭЗХ	

---oOo---